ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 19 Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Тусгагдсан зорилт:1.1."Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын шинэ баазын барилгын II ээлжийн ажлын явцад хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:2018 онд Нийслэлийн зураг төслийн хүрээлэн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн II ээлжийн барилга угсралтын төслийг 4,3 га газарт нийт 13 ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн. 2023 онд бүрэн ашиглалтад оруулахаар гүйцэтгэгч, хуулийн этгээдүүдэд ДХШХ сард 2-3 удаа хяналт тавин ажилласан. НЗДТГ-ын хөрөнгө оруулалтын газар, гүйцэтгэгч компаниуд, захиалагч нарыг ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар уулзалтуудыг улирал бүр үе шаттай зохион байгуулсан. Нэмэлтээр автобус паркийн цахилгаан хангамжийн ажлыг "Эрчим хайрхан" ХХК гүйцэтгэхээр 2,208,600,000 төгрөгийн гэрээ байгуулан 770,559,972 санхүүжилт авсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 13 ажлаас ШТС, Кузов засвар-угаалга, уурын зуух, цахилгаан хангамжийн барилгуудыг улсын комиссоор оруулсан. Дүгнэлт гараагүй.
Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Барилга угсралтын ажлын гүйцэтгэл-80%

Тусгагдсан зорилт:1.2.Парк шинэчлэлтийн хүрээнд шинээр ирсэн автобуснуудын камерыг онлайн дамжуулалтад холбох ажлыг хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.2.1.2023 оны 1 дүгээр улиралд орж ирсэн 112 тээврийн хэрэгслийг хүлээн авч, "Улаанбаатар Смарт Карт" ХХК-тай хамтран шугамын үйлчилгээнд гаргахад бэлэн болгосон.
1.2.2.Онлайн дамжуулалтыг холбох ажилтай холбогдуулж хяналтын камер, хард зэргийг оролцуулан тестерлүүлсэн
1.2.3.112 тэрэгний онлайн камертай холбох серверт шаардагдах зардлыг төсөвт суулгах хүсэлтийг НЗДТГ-т санал хүргүүлсэн.
1.2.4.Тээврийн хэрэгслийн хяналтын камерын үйл ажиллагаа, онлайн дамжуулалтыг сайжруулах ажлын хүрээнд БНХАУ-аас ирсэн мэргэжилтнүүдэд цахилгаан тэрэг-18, Golden dragon-10 тээврийн хэрэгслийн судалгааг тус тус Монгол, Англи хэл дээр хөрвүүлэн гаргаж өгсөн.
Хэрэгжилт:80%

Хүрсэн үр дүн:Байгууллагын хэмжээнд шугамын үйлчилгээний 12 чиглэл нэмэгдсэн бөгөөд үүнтэй холбогдуулж, гаралт, рейсийн тоо нэмэгдсэн. Онлайн холболтын ажил судлагдаж байна.

Тусгагдсан зорилт:1.3.Байгууллагын үйл ажиллагааны эхний хагас жил, жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.3.1.Байгууллагын 2022 оны бүтэн жилийн тайланг 14 чиглэл, 82 арга хэмжээний дагуу тодорхой үр дүнд хүрсэн буюу 87,5%-аар үнэлж, газрын даргад танилцуулсан. Өмнөх оны мөн үеэс 1%-аар өссөн үзүүлэлттэй.
1.3.2.НЗДТГ-аас ОНӨААТҮГазруудын үйл ажиллагааны хагас жилийн тайланг дүгнэхтэй холбогдуулж үйлдвэрийн газрын тайланг 3 чиглэл 12 үзүүлэлтийн дагуу 95,2%-аар үнэлж, 2023 оны 06 сарын 29-ний өдөр UB.erp цахим системээр хүргүүлсэн.

1.Хэрэгжих шатанд явж байгаа 21 арга хэмжээг эрчимжүүлж ажиллах
2.Тайланд тоо үзүүлэлт, статистик мэдээлэл, харьцуулалтыг түлхүү ашиглах
3.Найруулга зүй, үгийн сонголт, зөв бичих дүрэмд анхаарах
4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулж тайлагнах зөвлөмжийг тус тус хүргэсэн.
1.3.2.НЗД-ын А/727 дугаар захирамжийн дагуу НЗДТГ-т улирал бүр тайлан хүргүүлж ажиллах шийдвэрийн хүрээнд ДХШХ 4 дүгээр улиралын байдлаар 90 зөрчил, түүнд харгалзсан арга хэмжээний ажлын мэдээллийг хүргүүлж тайлагнасан.
Хэрэгжилт:100%

Хүрсэн үр дүн:2022 Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж газрын даргад танилцуулсан. Тайлан бүрэн хангалттай гэж дүгнэсэн.

Хэсгийн дундаж үнэлгээ:83,3%

ХОЁРДУГААР БҮЛЭГ:ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Тусгагдсан зорилт:2.1.Байгууллагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Байгууллагын хэмжээнд 2023 оны эхний хагас жилд Монгол улсын 9 хуулийн 10 зүйл заалтыг 94,8%, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 зүйл заалтыг 100%, Засгийн газрын 1 тогтоолын 2 зүйл заалтыг 100%, Нийслэлийн Засаг даргын 5 захирамжийн 6 зүйл заалтыг 63%, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 1 тэмдэглэлийн 1 даалгаварыг 100% тус тус биелэсэн. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланд нийт 17 шийдвэрийн 20 зүйл заалтыг 91,6% буюу бүрэн хэрэгжсэн байдлаар дүгнэв. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 43 дугаар тогтоолын 1.7 заалт Нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд үе шаттай шилжүүлэх ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд туршилтын гэрээгээр БНХАУ-ын ""Skywell" үйлдвэрийн 37 дан, 2 давхар 10 нийт 47 цахилгаан автобус, цахилгаан цэнэглэх 4 цэг ашиглалтад оруулсан.112 ширхэг евро-5 түлшээр ажилладаг Хятад улсад үйлдвэрлэсэн "Нанжин Голден Драгон Бус" автобусаар парк шинэчлэлт хийж, үйлдвэрийн газрын 184 тээврийн хэрэгслээс 159 буюу 86,5%-ийн бүрэн шинэчлэгдсэн.2022 онд ашиглалтын хугацаа дуусан каунти маркын 25 ширхэг автобус нь нийслэл хотын агаарын бохирдолд нөлөөлж байгаа бөгөөд байгаль орчинд ээлтэй нийтийн тээврийн автобусаар парк шинэчлэлтийг хийх шаардлагатай гэж үзсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт 91,6%

Тусгагдсан зорилт:2.2.Газрын даргын тушаалаар батлагдсан журам, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
Тушаалын төслийг үндэслэн газрын даргын А/тушаал 32, Б/тушаал 189 тушаалыг хэвлэмэл хуудсанд буулгаж баталгаажуулан цахимжуулсан. Хяналт шалгалтын явцад тушаалыг шинэчлэн батлахдаа өмнө мөрдөгдөж байсан тушаалыг хүчингүй болгодогүй нь тогтоогдсон.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:ЗУХНХ-т тушаалын хэрэгжилтийг хэлтэс, албан тушаалтнаас хэрэгжүүлж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн.

Тусгагдсан зорилт:2.3.Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.1.Үйлдвэрийн газрын даргын А, Б тушаалд ХДЖ-ын холбогдох заалтыг үндэслэл болгон авч, хэрэгжүүлж ажилласан

2.3.2.Хөдөлмөрийн дотоод журмын 33.1 дэх хэсэгт заасны дагуу хэрэгжилтийг тооцон дүгнэдэггүй.

Хяналт, шалгалтын явцад холбогдох мэргэжилтэн ямар нэгэн мэдээлэл гаргаж өгөөгүй. Дүгнэх боломжгүй.

Хэрэгжилт 100%.

Хүрсэн үр дүн:Дүгнэх, тайлагнах загварыг УШ/01-ийн хүрээнд хавсралт болгон хүргүүлж, хавсралтын дагуу тайлагнахыг зөвлөсөн.

Тусгагдсан зорилт:2.4.Байгууллагын удирдах ажилтны шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.4.1.Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний ирцийн мэдээг сайн бүртгэж, хөтөлсөн.

2.4.2.Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг сар улирлаар тооцон гаргаж ДХШХ-т ирүүлж, хянуулсан.

2.4.3.Жилийн эцсийн байдлаар шуурхай хуралдаанаас 414 үүрэг даалгавар өгөгдснөөс биелэлт 86,7% тай. Үүрэг даалгавар хамгийн өндөр биелэгдсэн нь 6 сард 32 даалгавар 94,6%.

Шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлтийн тайланг бүрэн гүйцэд авч тайланд тусгаж байх, тоо баримт дурдах, үг үсэг утга найруулга дээр анхаарч ажиллах шаардлагатай. Хэрэгжилт:100%

Хэсгийн дундаж хувь 100 %

ГУРАВДУГААР БҮЛЭГ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Тусгагдсан зорилт:3.1.Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Газрын даргын 01 дүгээр удирдамжийн дагуу ЗУХНХ-ийн нэгдүгээр улиралын үйл ажиллагааг 15 үзүүлэлтээр 83,5%-аар үнэлж, газрын даргад танилцуулсан. Хяналтын ажлын дүгнэлтийг 26 давуу тал, 24 сул тал, болон ажил сайжруулах 14 тус хэлтэст хүргүүлсэн.

Зөвлөмж:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа үг үсгийн алдаагүй, биелэлтийн хугацаан дээр нь анхаарч ажиллах
- Үүрэг даалгаврын биелэлтийг чанаржуулах
- Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлуулах
- Албан тушаалын жагсаалтыг батлуулж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах
- Тушаалын үндэслэл, бичвэр хэсгийг үг үсгийн алдаагүй бичих
- Тушаалыг хэвлэмэл хуудсыг дугаарлах, зарцуулалтын тайланг гаргаж, хэвлэмэл хуудас хуудас устгахдаа буруутай этгээдэд хариуцлага тооцож байх
- Байгууллагын дэргэдэх БНШК-ын үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 25.1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэн, үйл ажиллагааг тогтмолжуулах, комиссын дүрмийг шинэчлэх
- Баримт бичиг зохион бүрдүүлэх, боловсруулалтыг баримт бичгийн стандарт (MNS5140:2021) шаардлагад нийцүүлэн ажиллах
- Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

- Монгол Улсын Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг мөрдөж ажиллах
- Байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлтийг хугацаанд хийж, данс бүртгэлийг үйлдэж баталгаажуулж ажиллах
- Хүний нөөцтэй холбоотой дэлгэрэнгүй болон бусад судалгаануудыг цаг хугацаанд нь гаргаж байх.
- ERP цагийн бүртгэлийн системийн гадуур ажилтай үеийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах (гадуур ажилласан ажлын товч тайлан, чөлөө авсан хуудас зэргийг хавсаргах)

.Ажилтны хувийн хэргийн баяжилтыг тогтмол хийж ажиллахад анхаарах

Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, гаргасан зөрчлүүдийг арилгаж хийсэн ажлын дүн мэдээг, холбогдох баримт материалын хамт 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Дотоод хяналт, шалгалтын хэлтэст ирүүлэхийг зөвлөсөн. Зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлыг 6 дугаар сард ирүүлсэн. **Хэрэгжилт:100%**

Хүрсэн үр дүн:Захиргаа, удирдлага, хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 85,3% үнэлж, газрын даргад танилцуулсан. Цаашид үйл ажиллагаандаа ашиглах дотоод журмын хэрэгжилтийн тайлан, тушаалын төсөл боловсруулах маягт зэргийг хавсаргасан.

Тусгагдсан зорилт:3.2.Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.2.1.Хүний нөөцийг чадавхжуулах тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан. 7 бүлэг 61 зүйл заалт бүхий хөтөлбөр. 5 бүлэг 18 арга хэмжээ төлөвлөж, 14 арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- 3.2.2.Хүний нөөцийг чадавхжуулах тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн үйл ажиллагааг 2023 оны хагас жилийн байдлаар тайлагнаж ирүүлсэн.
- 3.2.3.2023 оны 3 дугаар улирлын байдлаар өглөө А-аар ирж давхардсан тоогоор 750 жолоочид эрүүл мэндийн үзлэг хийсэн.
- 3.2.4.1-р улирлын байдлаар захиргааны нийт ажилчдыг витаминжуулж, хөдөлгөөнт дасгал хийлгэх ажлыг эхлүүлсэн.
- 3.2.5.Хүүхдийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд байгууллагын нийт ажилчдад бэлэг гардуулсан.
- 3.2.6.Үйлдвэрийн газрын ажилчдын дунд "Налгар намар-2023" өдөрлөгийг зохион байгуулсан.
- 3.2.7.Хичээлийн шинэ жилийг угтан ажилчдын 40 хүүхдэд хичээлийн иж бүрэн хэрэгсэл бэлэглэсэн.
- 3.2.8.Даргын зөвлөлийн ээлжит хурлаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан шалгагч, үйлчилгээний ажилтан С.Нямсүрэнд буцалтгүй тусламж болгон 2,000,000 төгрөг хандивласан.
- 3.2.9.Шинээр гэр бүл болсны тэтгэмж
- 3.2.10.2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааг дүгнэн тогтвортой суурьшилтай ажиллаж буй ажилчдаа урамшуулж, 25,000,000 төгрөг бүхий байрны урьдчилгаа-2, таван ханатай гэр-2, сургалтын төлбөр-1 тус тус олгосон. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:"Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулж мөрдөж ажиллах, ажилчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах талаар зөвлөмж өгсөн.

Тусгагдсан зорилт:3.3.Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтэд хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.3.1.Үйлдвэрийн газрын 2023 оны худалдан авалтын төлөвлөгөөнд 15,341,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл арга хэмжээ нийслэлийн хөрөнгөөр 25 төсөл арга хэмжээ нь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсаны 15 худалдан авалтыг tender.gov.mn-ээр цахимаар зарлан, үр дүн гарч, гэрээ хийгдсэн. Дээрх арга хэмжээний төсөвлөгдсөн өртөг 11,180,800,000 төгрөг бөгөөд 9,949,143,784 төгрөгөөр гэрээ байгуулж ажилласан.
- 3.3.2.Байгууллагын худалдан авах ажиллагааны Шилэн дансны мэдээллийг СБХ-ийн эдийн засагчид 2023 оны хагас бүтэн жилийн байдлаар хүлээлгэн өгсөн Хэрэгжилт:100%

Хүрсэн үр дүн:Байгууллагын худалдан авах ажиллагааны биелэлт төлөвлөгөөний дагуу явагдаж, нийлүүлэлтийг захиалагчийн захиалгын дагуу гэрээт байгууллагууд нийлүүлэн ажилласан.

Тусгагдсан зорилт:3.4.Түлш, тос, тослох материалын зарцуулалтад хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.1.Өдөр тутмын хөдөлгөөний мэдээнд хяналт тавьж, цагийн гүйцэтгэл, алдагдсан цагийн түвшин, масло тосолын зарцуулалтад мэдээллийн сан бүрдүүлж, сар бүр хэлтсийн даргад танилцуулсан. 5 сарын нийлбэр дүнгээр 1265,5л масло, 1713 л тосол зарцуулсан. Маслын зарцуулалт хамгийн их:

- 1.Гр 3-033 31 хоногт 65,5л
- 2.Гр 3-035 36 хоногт 90л
- 3.Гр 3-038 20 хоногт 70л
- Тосолын зарцуулалт хамгийн их:
- 1.Гр 3-033 44 хоногт 107л
- 2.Гр 3-022 30 хоногт 81,5л
- 3.Гр 3-047 30 хоногт 82л

Тос маслын зарцуулалтын тайлан нь хөдөлгөөний мэдээн дээрх бичилтээс зөрүүтэй байсныг жилийн эхний хагаст илрүүлж, цаашид дээрх судалгааг хөдөлгөөний мэдээний мэдээллээр гаргаагүй.

Хүснэгт 1.Эхний 5 сарын байдлаар масло тосолын зарцуулалт их байсан тээврийн хэрэгсэл

д/д	Гараж №	Тосол		Гараж №	Масло	
		Хоног	Литр		Хоног	Литр
1	3-033	44	107	3-033	31	65,5
2	3-022	30	81,5	3-035	36	90
3	3-047	30	82	3-038	20	70
нийт			270	нийт		225,5

3.4.2.Тайлант онд "Golden dragon" маркийн 100 ш тээврийн хэрэгслийг шугамын үйчилгээнд нэвтрүүлсэн. Газрын даргын А/31 дугаар тушаалын хүрээнд Түлшний норм тогтоох ажлын хэсэг байгуулагдан 2 сарын турш хэлтсийн ажилчид ажилласан. Түлшний нормыг 33,6 л-ээр тогтоосон.

3.4.3.Түлшний хэтрэлтийг багасгаж, хэмнэх үүднээс 5 дугаар сараас өдөр бүр инженер, техникийн ажилчид Арвайн үндэс салбарын ШТС-д 21:00-24:00 цаг хүртэл түлш олголтод хяналт тавьж ажилласан.

3.4.4.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын хүрээнд 6 удаа оройн уртасгасан цагаар түлшний зарцуулалтад хяналт тавьж 2 удаа түлшний хулгайн хэрэг илрүүлж, нотлох баримтыг ЗУХНХ-т хүргүүлсэн.

3.4.5.Хяналтын камерын тусламжтай 3 удаагийн шалгалтаар 11 хүнд холбогдох түлш завшсан хэргийг нотлох баримтын хамт ЗУХНХ, ТҮХ-д тус тус хүргүүлсэн. Авагдсан арга хэмжээний талаарх мэдээллийг газрын даргын тушаалаар хавсралт болгон ирүүлсэн Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Санхүү, бүртгэлийн хэлтэст зөвлөмж хүргүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.5.Сэлбэгийн материалын зарцуулалтын тооцоонд хийх хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 3.5.1.Байгууллагын сэлбэг материалын хадгалалт, зарцуулалтын хагас жилийн тооллогод хяналтаар Хяналтын оператор Ч.Солонго, комиссын даргаар хэлтсийн дарга Л.Отгонбаатар нар 06.01.-30-ны өдөр ажилласан.

Каунти маркийн автобусны сэлбэг материал:2023 оны 01 сарын 01 нд 266,832,378.62 төгрөгийн сэлбэг материлын үлдэгдэлтэй Тайлант хугацаанд 304,860,700 төгрөгийн сэлбэг материал орлогод авч 298,080,401.96 төгрөгийн сэлбэг материалын зарлага гарсан.Хагас жилийн эцсийн тооллогоор 4,126.95 ширхэг 273,612,676.00 төгрөгийн сэлбэг материалын үлдэгдэлтэй байсан.Тооллогоор дутагдсан хөрөнгө байхгүй

Эко маркийн сэлбэг материал:2023 оны 1 дүгээр сарын 01 нд 347,341,936.51 төгрөгийн сэлбэг материалын эхний үлдэгдэлтэй. Орлогод авсан сэлбэг байхгүй.10,169,522.23 төгрөгийн сэлбэг материалыг зарлагадсан.Хагас жилийн тооллогоор т24,887.30 ширхэг 337,172,417 төгрөгийн сэлбэгийн үлдэгдэлтэй байна.Тооллогоор дутагдсан хөрөнгө байхгүй.

Дэу маркийн сэлбэг материал:2023 оны 01 сарын 01 нд 5021.2 тоо ширхэг бүхий 127,949,039.02 төгрөгийн сэлбэг материалын эхний үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд 41,923,250 төгрөгийн сэлбэг материалыг орлогод авч 39,399,677.56 зарлага гарсан.Тооллогоор 5,250.20 ширхэг 130,472,611 төгрөгийн сэлбэг матеиалын үлдэгдэлтэй..Тооллогоор дутагдсан хөрөнгө байхгүй.

Аж ахуйн автомашины сэлбэг материал:2023 оны 01 сарын 01 нд 00 төгрөгийн сэлбэг материалын үлдэгдэлтэй. тайлант хугацаанд 13,791,000 төгрөгийн сэлбэг материалыг орлогод авч 7,223,900 төгрөгийн сэлбэг зарлагадаж 66 ширхэг 6,567,100 төгрөгийн сэлбэгийн үлдэгдэлтэй байна.Тооллогоор дутагдсан сэлбэг материал байхгүй.

Хуучин сэлбэг 2023 оны 01 сарын 01 нд 00 төгрөгийн сэлбэгийн үлдэгдэлтэй тайлант хугацаанд 4,079,500 төгрөгийн сэлбэг материал орлогод авч 4,079,500 төгрөгийн сэлбэг материалыг зарлагасан.Тооллогоор үлдэгдэл сэлбэг байхгүй.

Сэлбэг материал /XML6105J15C/ 2023 оны 01 сарын 01 00 төгрөгийн сэлбэг материалын эхний үлдэгдэлтэй тайлант хугацаанд 4,315,150 төгрөгийн сэлбэг материал орлого авч 1,899,500 сэлбэг материал зарлагадсан.Тооллогоор 6 ширхэг 2,415,650 төгрөгийн сэлбэг материалын үлдэгдэлтэй. Дутагдсан хөрөнгө байхгүй. Хэрэгжилт 100%

Тусгагдсан зорилт:3.6.Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу СБХ-ийн үйл ажиллагаанд удирдамжтай шалгалт хийж, 20 дэд ажлын хүрээнд хагас жилийн үйл ажиллагааг 83%-тай дүгнэсэн. Үүнд үйл ажиллагааны ололттой тал-7, дутагдалтай тал (зөрчил)-12 тус тус ялган дүгнэж, ажил сайжруулах доорх зөвлөмжийг хүргүүлсэн.

1.Хэлтсийн болон ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт гаргахдаа тоон болон чанарын судалгааны аргыг ашиглаж, статистик үзүүлэлттэй тайлагнаж хэвших.

2.Тайлан болон, анхан шатны баримт бичгийг зөв бичих дүрмийн дагуу бичих

3.Архив, албан бичгийн стандартыг хангаж ажиллах

4.Шилэн дансанд мэдээллийг цаг хугацаанд нь хоцроолгүй оруулж байх

5.Шатахууны зарцуулалтын хяналтыг сайжруулах

6.ШТС-ын түгээгчийн бүртгэлийг хяналтын камерын бичлэгээр баталгаажуулах

7.Шатахуун түгээгчийн 52-р маягтын бичилтийн үнэн зөв мэдээлэлд анхаарч, сайжруулах

8.Шатахууны нийлүүлэгч гэрээт байгууллагын гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, сайжруулах ажил зохион байгуулах

9.Аж ахуйн тэрэг, сургуулийн автобусанд замын хуудас олгох

10.II дугаар улирлын кредит картын зарцуулалтыг нөхөн бичилт хийх.

11.Сургуулийн автобусны түлшний нормыг тогтоох

Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, гаргасан зөрчлүүдийг арилгаж хийсэн ажлын дүн мэдээг, холбогдох баримт материалын хамт 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дотоод хяналт, шалгалтын хэлтэст ирүүлэхийг зөвлөсөн. Хариу ирүүлээгүй Хэрэгжилт 80%

Тусгагдсан зорилт:3.7.Нийтийн тээврийн үйлчилгээний газартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд бүртгэлээр хяналт, шалгалт зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.7.1.ННТГ-тай байгуулсан гэрээний үүргийн биелэлт тайлант оны гуравдугаар улиралын байдлаар 85,6% буюу "Сайн" үнэлэгдсэн.

3.7.2.Зөрүү цаг гуравдугаар улиралын байдлаар нийт 9584:47:30. III улиралд зөрүү цаг 1,2 дугаар улиралаас 2 дахин өссөн үзүүлэлттэй буюу 4594:00:00.

3.7.3.Өдөр тутмын хөдөлгөөний мэдээнд үндэслэн мэдээллийн сан бүрдүүлж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, 2023 оны алдагдсан цагийн байдлыг (Цэнэглэлтийн цаг, техникийн саатал, ашиглалтын саатал, жолоочоос хасах цаг, эх авалт, зогсоолд зогсоогүй зөрчил, оройн буулт) улирлын дүнгээр нэгтгэхэд I улирал-7770:19:30, II улирал-7976:56:00, III улирал-10443:07:00 буюу III дугаар улиралд цагийн алдагдал ихэссэн. Богино эргэлт, буух цэгийн зөрчлийг зөвхөн зургаадугаар сараас эхлэн ангилж эхэлсэн тул улирлын нэгдсэн дүнд оруулж тооцоогүй.

1.Цэнэглэлтийн цаг тайлант оны гуравдугаар улиралд нэгдүгээр улирлаас 2,3 дахин багассан. Нэгдүгээр сард хамгийн өндөр буюу 1152:05:00 цагийг цэнэглэлтэд зарцуулсан

2.Техникийн саатал 2 дугаар улиралд 980 цагаар багассан ч гуравдугаар улиралд 202 цагаар өссөн.

3.Ашиглалтын саатал оны гуравдугаар улиралд нэгдүгээр улирлаас 2 дахин буюу 2763:31:00 болж өссөн нь тайлант оны хугацаанд хамгийн өндөр хасагдах цагаар бүртгэгдсэн. Өмнөх оны мөн үеийнхээс 1000 цагаар өссөн үзүүлэлттэй.

4.Жолоос хасах цаг хоёр дугаар улиралд 5,4 дахин, гурав дугаар улиралд 6,4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй.

5. Эх авалт, зогсоолд зогсоолгүй, буултын зөрчил улирал бүр өссөн үзүүлэлттэй..

График 1. Алдагсан цагийн харьцуулалт (2023 оны 11 сарын байдлаар)



	Цэнэглэлт цаг	Техникийн саатал	Ашиглалт саатал	Жолооч оос хасах	Эх авалт	Зогсоолд зогсоогүй зөрчил	Оройн буулт	Богино эргэлт	Буух цэгийн зөрчил
1 Улирал	2671:47:	2270:45:	1431:20:	431:19:3	544:40:0	276:57:0	143:30:3		
2 Улирал	2029:37:	1290:28:	1280:52:	2359:07:	408:40:0	478:25:0	129:47:0	282:46:0	
3 Улирал	1139:43:	1492:29:	2853:38:	2763:31:	1167:37:	583:53:0	442:16:0	304:53:0	80:40:00

Үйлдвэрийн газар тайлант онд 2, 4, 9, 10 дугаар саруудад шат дараатай гаралтаа нэмэгдүүлж 975:00:00 цагийн даалгаварт цаг 1597:31:00 болж ессентэй холбогдон нийтийн тээврийн салбарын тулгамдсан асуудал болох хүний нөөцийн хомсдолоос үүдэлтэй эх авалтын саатал, ашиглалтын саатлууд нэмэгдсэн гэж үзэж байна. Харин жолоочоос хасах цаг, буулт, буух цэгийн зөрчил, зогсоолд зогсоогүй зөрчил зэрэг цагийн алдагдлууд нь жолоочийн ур чадвар, санаачлагатай холбоотой учраас жолооч нарыг чадавхижуулах нэн шаардлагатай юм. Ингэснээр эхний гурван улирлын байдлаар 7689:25:30 цагийн алдагдлыг бүрэн бууруулах боломжтой.

Хэрэгжилт:100%

Хүрсэн үр дүн:Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст зөвлөмж хүргүүлсэн. Алдагдсан цагийг багасгах үүднээс ТҮХ нэг сарын кампанит ажил зохион байгуулж, тодорхой цэгүүдийн эцсийн буудлууд дээр инженер, техникийн ажилчдыг уртасгасан цагаар ажиллуулсан.

Хэрэгжилт-100%

Тусгагдсан зорилт:3.8.Нийтийн тээврийн үйлчилгээний MNS5012:2011 стандартын шаардлагын хэрэгжилтэд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.8.1.Тайлант хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээний MNS5012:2011 стандартын шаардлагын хэрэгжилтэд хяналт, шалгалтын ажлыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 61 зөрчил илэрсэн. Зөрчил дутагдлыг арилгах талаар Тээвэрлэлт, үйчилгээний хэлтэс, Техник, технологийн хэлтэст зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын тайланг холбогдох хэлтсүүдээс тус бүр 1 удаа ирүүлсэн.

3.8.2.Газрын даргын 2022 оны А/55 дугаар тушаалын дагуу хэлтсийн ажилчид хариуцсан тэрэгний үзлэг шалгалтыг 4 удаа зохион байгуулж, үзлэг шалгалтын хуудсаар илэрсэн зөрчлийн тоо, хийсэн ажлын тайланг ЗУХНХ-ийн дарга П.Алтантөгсөд хугацаанд нь хүргүүлж ажилласан. Үзлэг шалгалтыг хийсэн ажлын үр дүнг тооцож ажилчдад урамшуулалт цалинг олгосон. Зөвлөмжийн дагуу арга хэмжээ зохион байгуулж, нийт илэрсэн зөрчлийг 98,2%-тай арилгасан.

3.8.3.Хариуцсан тэрэгний их цэвэрлэгээг сар шинийг угтан орой А-аар ажилласан.

3.8.4.Тээврийн хэрэгслийн гадна дотор угаалга цэвэрлэгээ, суудлын бүрээсийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих зорилгоор шугамын үйлчилгээнд 4 удаа хяналт тавин 118 зөрчил

илрүүлсэн. 2023 07 сарын 19-ний өдөр газрын даргын шуурхай үүрэг даалгавараар Ч:1, Ч:29а, Ч:29б, Ч:75, Ч:60, Хо:13, Хо:8, Хо:9, Хо:10а, Хо:10б, Хо:12 чиглэлийн 48 тээврийн хэрэгсэл (давхар автобус-5, цахилгаан автобус-8, голден драгон (дизель)- 29, каунти-4) хамруулж, үр дүнг газрын даргад танилцуулан, 14 хоногийн ажил сайжруулах төлөвлөгөө боловсруулан хүргүүлсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын тайланг ТТХ-2, ТҮХ хэлтсүүдээс тус бүр 1 удаа ирүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.9.Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.
ТҮХ-ийн үйл ажиллагаанд Хяналт, шалгалтын ажлыг гүйцэтгэхдээ газрын даргын 2023 оны УШ/02 дугаар удирдамжийн дагуу ажилласан.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:2023 оны эхний 05 сарын байдлаар удирдамжид тусгагдсан 15 дэд шалгуурын хүрээнд 73%-ийн гүйцэтгэлтэй буюу цаашид эрчимжүүлэн ажиллах шаардлагатай гэж үнэлж, газрын даргад танилцуулсан.

Хяналт, шалгалт хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс 15 ололттой тал, 19 сул тал, ажил сайжруулах 14 зөвлөмж ТҮХ-д хүргүүлсэн.

Зөвлөмж:

1.Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа өмнөх оны ажлын алдаа дутагдал, ололт дээр тулгуурлан, үг үсгийн алдаагүй, биелэлтийн хугацаан дээр нь анхаарч ажиллах

2. Үүрэг даалгаврын биелэлтийг чанаржуулж, үр дүнд анхаарч ажиллах

3.Хэлтсийн хэсгийн дарга, тээвэр хөдөлгөөн зохицуулагч нарыг ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу ажил үүргээ сайжруулж анхан шатны бичиг баримтыг стандартын дагуу зөв хөтлөх

4.Ашиглалтын саатал, жолоочоос хасах цагийг тодорхой түвшинд бууруулах эрчимтэй ажил зохион байгуулах
5.Хэсгийн дарга нар хэсгийн жолооч нарын ажлын үзүүлэлтийг дүгнэж, ахлах инженер, хэлтсийн дарга нартай тайлагнаж, баталгаажуулж ажиллах
6.Тээвэр хөдөлгөөн зохицуулагч нар Улаанбаатар Смарт Карт ХХК-аас авах цагийг яагаад бүрэн авч чадахгүй зөрүү цаг гаргаж байгаад дүгнэлт хийж цагийг бүтэн авч цагийн түвшинг өсгөх
7.Жолооч нарын хөдөлмөр зохион байгуулалтад анхаарах, А жижүүрийг хуваарийн дагуу хийлгэж байх
8.Замын хуудсанд өөрчлөлтийг цаг тухай бүрт нь хийж байх
9.Хэлтсийн дарга, ахлах инженертэй хамтран хэсгүүдийн ажлын гүйцэтгэлийг дүгнэх хуудас гаргаж, үр дүнг тооцон ажиллах
10.Хэлтсийн дарга, ахлах инженертэй хамтран хэлтсийн инженер техникийн ажилчдын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд бодит дүгнэлт өгч, үр дүн, хариуцлагыг тооцож ажиллах
11.Зам тээврийн осол зөрчил, бусад зөрчил гаргасан ажилчдад арга хэмжээ тооцохоос гадна ямар арга хэмжээ зохион байгуулсан, гарсан үр дүнгийн талаар тооцож, холбогдох баримт материалыг стандартын дагуу бүрдүүлж ажиллах
12.Хэсгийн дарга нарын фонд цагийн 30%-ийг жолооч нарын сахилга бат, үйлчилгээний соёлыг дээшлүүлэхэд анхаарч, шугамын үйлчилгээнд хяналтаар ажилласан байдлаар тооцох
13.Хэлтсийн инженер техникийн ажилчид тус бүрээр ажил сайжруулах, ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг зөв боловсруулах тал дээр ахлах инженер зөвлөж, төлөвлөгөөг боловсруулж, мөрдүүлж, үр дүнг хугацаанд нь дүгнэж ажиллах

14.Тушаалын хэрэгжилт, шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилт, даргын зөвлөлийн үүрэг даалгавар гэх мэт заавал биелэгдэх ажлын биелэлтийг албажуулан, мэдээллийн сан үүсгэх Хэрэгжилт:90%

Хүрсэн үр дүн:ТҮХ-ийн эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг 73%-аар үнэлсэн. Зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган, гаргасан зөрчлүүдийг арилгаж хийсэн ажлын дүн мэдээг, холбогдох баримт материалын хамт 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг зөвлөсөн. Хариу ирүүлээгүй.

Тусгагдсан зорилт:3.10.Нийтийн тээврийн шугамын үйлчилгээний цаг, рейсийн алдагдалгүй, ТВОХ-д бүртгэлээр хяналт, шалгалтыг зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тайлант хугацаанд ТВОХ-ын зөрчилтэй цаг 1564:13:30 цаг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 237:27:30 цагаар өссөн.

2023 оны 5 сарын байдлаар ТВОХ-ын зөрчил сар бүр буурсан. Тухайлбал 01 сард 349:13:30 байсан бол 05 сард 281:18:00 цаг болсон. Тайлант оны эхний 11 дүгээр сарын байдлаар зам тээврийн ослоос шалтгаалсан саатлын цаг 1079:21:00. Сар бүр тогтмол өссөн бөгөөд жишээлбэл, 1 дүгээр сард саатлын цаг 60:15:00 байсан бол 11 сард 3 дахин өссөн буюу 197:45:00 болсон. Энэ нь гаралт нэмэгдсэнтэй холбоотой. Хэрэгжилт 100%

График 2.ТВОХ-ын зөрчил 2022, 2023 оны 5 сарын байдлаар

Хүрсэн үр дүн:Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст зөрчил арилгах зөвлөмж хүргүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.11.Техник, технологийн хэлтэст 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.11.1.Өдөр тутмын хөдөлгөөний мэдээнд тулгуурлан Техникийн саатлын цагийг гаргахад хагас жилийн байдлаар 3191:32:30 цаг гарсан. Энэ нь 2022 оны мөн үеийн үзүүлэлтээс 2 дахин буюу 3137:33:00 цагаар буурсан.

3.11.2.Тус хэлтсийн үйл ажиллагааг 2023 оны эхний хагас жилийн байдлаар удирдамжид тусгагдсан 9 дэд шалгуурын хүрээнд 72%-ийн гүйцэтгэлтэй буюу цаашид эрчимжүүлэн ажиллах шаардлагатай гэж үнэлэв.

Хяналт, шалгалт хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс 2023 онд цаашид анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна.

2.Хэлтсийн ажилчид төлөвлөгөөний дагуу ажиллаж, тайлагнах (инженерүүд ажлын гүйцэтгэлээс хамаарч, тусдаа тайлагнах, ерөнхий механик,,,)
3.Засварын инженерүүд техник үйлчилгээг батлагдсан хуваарийн дагуу гүйцэтгэх.
4.ТҮ-I, II үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хяналт тавих
5.Техникийн I,II үйлчилгээг MNS4601:98 стандарт болон бусад холбогдох стандартуудын дагуу хийж гүйцэтгэх
6.Засварчдын ажиллах цагийн хуваарийг гаргахдаа ажлын цаг, хөдөлмөр зохион байгуулалтыг зөв тооцоолох, батлагдсан хуваарийн дагуу ажиллуулж хэвших
7.Баримтаар гарсан сэлбэг, материалын ашиглалт, зарцуулалтыг тодорхой тэмдэглэж байх (дээр дурдсан тухайлсан өдрүүдийн зарцуулсан эсэх нь тодорхойгүй сэлбэг материалын талаар тайлбарыг бичгээр ирүүлэх)
8.Засвар үйлчилгээний дэвтэрт тэмдэглэл хөтлөхдөө баллаж, дарахгүй байх
9.Шалгах механикууд тээврийн хэрэгслийн угаалга, цэвэрлэгээнд хяналт тавьж, шаардлага хангаагүй үед шугаманд гаргахгүй байх, өглөөний шуурхайд үнэн зөв мэдээлэх
10.Өдөр тутмын баримт материалын бичиг хэргийн стандарт, бүрдэлд анхаарах
11.Зөв бичих дүрэм, утга найруулгыг сайжруулах
12.Ажилчдад давтан зааварчилгааг тогтмол өгч хэвших
Удирдамжтай шалгалтын хариуг хугацаанд нь ирүүлсэн.
Хэрэгжилт:100%

Тусгагдсан зорилт:3.12.Засварын инженерүүдийн ажил үүргийн гүйцэтгэл, засварын хуваарь график мөрдөлтөд хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.12.1.Өдөр тутмын хөдөлгөөний мэдээнд хяналт тавьж, засварын мэдээний тэмдэглэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлж ажиллахад 2023 оны эхний 4 сарын байдлаар засвар үйлчилгээний тэргүүлэх шалтгаан нь мотор-11 тэрэг 162 удаа, цахилгаан-6 тэрэг 54 удаа, пийшин-14 тэрэг 38 удаа тус тус орсон. Үр дүнг хэлтсийн даргад илтгэх хуудсаар сар бүр танилцуулсан.
3.12.2. Гуравдугаар улиралын байдлаар мотор-149 удаа, шил-227 удаа тус тус засварын ажил хийгдсэн.
3.12.2.Хэлтсийн төлөвлөгөөний дагуу ТТХ-ийн үйл ажиллагаанд удирдамжтай шалгалтын ажлыг зохион байгуулж, инженерүүдийн хагас жилийн тайлан ба 11 дүгээр сард гуравдугаар улиралын тайланд тус тус хяналт тавин ажилласан.

1.Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад бичиг хэргийн стандарт, албан хэрэг хөтлөлт, боловсруулалт сайжирсан.

2.Хагас жилийн тайлан, улирлын тайлан зэргийг өссөн дүнгээр, ялгаатай байдлаар тайлагнаж хэвшсэн.

3.Засварт орсон тэрэгнүүдийн тэргүүлэх шалтгаан, сэлбэг зарцууллалт зэрэгт дүн шинжилгээ хийсэн.

4.Засварын инженер тус бүр ажлын гүйцэтгэлийг ялгаатай байдлаар тайлагнаагүй. (2022 оны жилийн эцсийн тайланд ажил сайжруулах зөвлөмж болгон оруулсан ч хэрэгжүүлээгүй.)
Хэрэгжилт:100%

Тусгагдсан зорилт:3.13.Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, стандартын үзлэг шалгалтыг зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.13.1.Техникийн бүрэн бүтэн байдлын үзлэгийг тайлант хугацаанд 4 удаа зохион байгуулж, 32 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах, ажлыг чанаржуулах талаар Техник, технологийн хэлтэст зөвлөмж, зөрчлийн хуудсыг хүргүүлсэн.
3.13.2.Сэлбийн эцсийн цэнэглэлтийн цэгт шугамын үйлчилгээнд хяналт тавьж, цэнэглэлтийн цагаар тээврийн хэрэгслийн угаалга цэвэрлэгээг хийх ажлыг үе шаттай

зохион байгуулсан. Шугамын үйлчилгээнд ажиллаж байсан 5 тээврийн хэрэгслийг их цэвэрлэгээнд хамруулсан.

3.13.3.Хяналтын ажилтан Б.Шинэбаатар, М.Доржханд нар 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн оройн буултаар 45 ширхэг улаан автобусны банк таг, нэмэлт шүүлтүүрийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажилласан. Зөрчил илрээгүй.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Техник, технологийн хэлтэст зөрчлийн хуудас хүргүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.14. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйн ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтэд хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.14.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсийн дарга П.Алтантөгс даргаар 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлуулсан.

3.14.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын байран дахь давтан зааварчилгааг инженер техникийн ажилчдад өгч, гарын үсэг зуруулан бүртгэлийг бүрэн хийсэн.

3.14.3.Техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажилгааны үзлэг шалгалтыг сард 3-4 удаа хийж хэвшсэн. Уг үзлэгээр 82 ширхэг галын хорны ажиллагаа муудсан байсныг сольсон. Автобусанд байрлах санамж галын хорын нөхөн хангалтыг хийж ажилласан.

3.14.4.Сургалт мэдээ мэдээллийг 2 удаа зохион байгуулсан..

Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан.

Тусгагдсан зорилт:3.15.Онлайн камерын тусламжтайгаар жолооч нарын ажил үүргийн гүйцэтгэлд хяналт, шалгалтыг зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.15.1.Онлайн камерын нийт 206 зөрчил бүхий мэдээг тайлант хугацаанд 10 удаа буюу сар бүр ТҮХ-т хүргүүлсэн. Жолооч нарын зөрчлийн дагуу авсан арга хэмжээний хариуг ТҮХ-ээс 3 удаа хариу ирүүлсэн.

3.15.2.Онлайн камерын хяналтаар анх удаа зөрчил гаргаж буй 83 жолоочид гар утсаар мэдэгдэж, зөрчил арилгуулах арга хэмжээг авч, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.

3.15.3.Зөрчилтэй холбоотой асуудлаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг хэсгийн дарга нарт таниулах, мэдээлэл дамжуулах 9 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.

3.15.4.Камерын зөрчлийн хариуг ТҮХ-ээс удаа дараа ирүүлээгүй тул арга хэмжээ тооцох тухай мэдэгдлийг 2023 оны 12 сарын 19-ний дотор тус хэлтэст хүргүүлсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Шугамын үйлчилгээнд ажиллаж буй жолооч нарын буй жолооч нарын гаргасан зөрчлийн тоо буурсан.

Тусгагдсан зорилт:3.16.Онлайн камерын системийн хэвийн үйл ажиллагааг өдөр бүр шалгах доголдол, гэмтэл илэрсэн үед "Улаанбаатар смарт карт" ХХК-д мэдэгдэж засварлуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.16.1.Нийтийн тээврийн парк шинэчлэлтэй холбоотой 112 шинэ тээврийн хэрэгслийг шугаманд гаргахад бэлдэж 2023 оны 1 дүгээр улиралд шөнийн цагаар 1, өдрийн цагаар 3 удаа "Улаанбаатар смарт карт"ХХК-тай хамтран ажилласан.

3.16.2.Шинээр орж ирсэн 112 тээврийн хэрэгслийн хяналтын камерын өнцгийг 100% өөрчилсөн. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн:Тээврийн хэрэгслийн хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

Хэсгийн дундаж үнэлгээ-98,7 %

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Тусгагдсан зорилт:4.1.Шилэн дансны хөтлөлт, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Байгууллагын шилэн дансны мэдээлэлд 2022 оны эдийн засгийн зорилтот түвшингийн биелэлт, Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, мэдээ тайланг хугацаанд нь байршуулсан. **Хэрэгжилт-100%**

Хүрсэн үр дүн:Байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдлыг хангаж ажилласан.

Тусгагдсан зорилт:4.2.Байгууллагын шударга байдал, мэдээлэл технологийн бодлогын хэрэгжилт, хэвлэл мэдээлэл, олон нийт, хүний нөөцийн ил тод байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:УШ/01-ийн хүрээнд зохион байгуулсан шалгалтын дүгнэлтээр:

УШ/01-ийн хүрээнд зохион байгуулсан шалгалтын дүгнэлтээр:

4.2.1.Үйлдвэрийн газрын вэб хуудсанд 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, ДХШХ-ийн төлөвлөгөө, тайлан. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө.

4.2.2.Төрийн албан хаагчийн ёс тухай хууль" батлагдсантай холбоотой байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн баталсан. Үүнтэй холбоотой https://bus3.mn албан ёсны сайтад дээрх мэдээлэл, шинэчлэгдсэн бүрэлдэхүүн, ажиллах журмыг нэг бүрчлэн байрлуулсан.

4.2.3.Зарласан тендерийн жагсаалт

4.2.4.https://bus3.ub.gov.mn/ 17 ажлын байранд нээлттэй ажлын байр зарлаж, 275 иргэнийг сонгон шалгаруулж, ажилд авсан.

4.2.5.Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан С. Адъяасүрэн холбоо барих утас:77002250 байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 2023 оны хагас, бүтэн жилийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.

4.2.6.Байгууллагын мэдээ мэдээллийг https://bus3.ub.gov.mn/ байгууллагын сайт-5, Зорчигч тээвэр гурав албан ёсны пэйж хуудсаар-27 https://mand.mn/ сайт, сайтын албан ёсны сошиал хуудсаар-24 нийслэлийн цахим мэдээллийн программаар-11, FM радиогоор өдөр бүр 5 удаагийн давтамжтай, Нийслэлийн мэдээ албан ёсны фейсбүүк пейж хуудсаар-5 удаа тус тус мэдээлж, хэвлэлийн 2 байгууллагатай гэрээний дагуу мэдээ мэдээллийг ил тод олон нийтэд мэдээлж ажилласан Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Байгууллагын ажилчдын нийгмийн асуудлыг тодорхой түвшинд шийдэж, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.

Хэсгийн дундаж үнэлгээ-100 %

ТАВ БҮЛЭГ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

Тусгагдсан зорилт:5.1.Дотоод хяналт, шалгалтын ажилтнууд болон хяналтын операторуудын ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1.1.Монголын дотоод хяналтын институт"-ын 1 сарын эрчимжүүлсэн онлайн сургалтад

1.Хэлстсийн дарга Л.Отгонбаатар- Дотоод аудит

2.Хяналтын ажилтан Г.Байгалмаа, М.Доржханд-"Хяналтын ажилтан" бэлтгэх сургалтад 2023 оны 05 сарын 02-06 сарын 10-ны хооронд тус тус суралцаж гэрчилгээгээ авсан. Сургалтын төлбөрийн 70%-ийг байгууллагаас, 30%-ийг суралцагч төлсөн.

5.1.2.

Хүснэгт 2.2023 оны эхний хагас жилийн сургалтын мэдээлэл

Д/д	Сургалтын байгууллага	Сургалтын нэр	Суралцагч
1	НЗДТГ	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал, анхаарах зарим асуудал	Хяналтын ажилтнууд
2	МУЗГ-ын тохируулагч агентлаг	Стандарт ба хөгжил хэлэлцүүлэг	Хяналтын оператор Ч.Солонго
3	JCI	"Өвсний үндэс" хэлэлцүүлэг	Хяналтын ажилтан Г.Байгалмаа
4	НЗДТГ	Хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал	Хяналтын ажилтнууд
5	ХАБЭААХА	Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх	Бүх ажилчид
6	Эмч	Сэтгэл судлал эрүүл мэнд	Бүх ажилчид
7	"Агула даатгал" ХХК	Тохиолдлыг бүртгэх	Бүх ажилчид

Хүрсэн үр дүн:Онол арга зүйн мэдлэг, туршлага дээшилсэн.

Тусгагдсан зорилт 5.2.Камер шүүлгэх талаар холбогдох байгууллага, иргэдээс ирсэн албан бичиг, өргөдлийг удирдлагын цохолтоор шийдвэрлэх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тайлант хугацаанд ДХШХ-д иргэний хүсэлтээр 150, цагдаагийн газрын хүсэлтээр 15 удаа тээврийн хэрэгслийн онлайн камерыг шүүсэн.

Камерын хүсэлтээр иргэдийн алга болгосон эд зүйлсийг илрүүлэх, цагдаагийн байгууллагын хэрэг илрүүлэлтийг сайжруулах, эрэн хайх ажиллагаанд оролцох, жолоочийн эрх ашгийг хамгаалах, тохиолдлыг баримтжуулах зэрэг олон талын ач холбогдолтой ажиллав. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Өргөдөл хүсэлтийг хуулийн хугацаанд барагдуулсан.

Тусгагдсан зорилт 5.3.Улаанбаатар смарт карт" ХХК-тай онлайн камерын засвар үйлчилгээ ашиглалтын тал дээр хамтарч ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.3.1."Улаанбаатар Смарт Карт" ХХК-тай хамтран каунти маркийн 15 тээврийн хэрэгслийн смартын тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг шалгаж, 1 тэрэгний тог, 3 тэрэгний эвдрэлтэй хяналтын камерыг сольсон.

5.3.2.Шугамын үйлчилгээд яваагүй, сэлбэггүй удаан зогссон 15 тээврийн хэрэгслийн онлайн камерийн лед дэлгэц 14ш, принтер 18 ширхэгийг тус тус "Улаанбаатар смарт карт" ХХК-д хүлээлгэж өгсөн.. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Онлайн камерын хэвийн үйл ажиллагаа, техникийн бэлэн байдлыг хангаж

Тусгагдсан зорилт:5.4.Шинээр санаачлан хийх ажлын хүрээнд байгууллагын захиргаанаас жолооч нарыг нэгдсэн мэдээллээр хангах системийг нэвтрүүлэх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.4.1.Акталсан тэрэгнүүдээс буулгаж, нөөцөд байсан камеруудыг ашиглаж 2 байршлыг онлайн камержуулсан.

5.4.1.1.Сэлбийн цэнэглэлтийн цэгийн 3 байршилд хяналтын камер суулгасан. *(Зураг 1)*

5.4.1.2.Түрээсийн гэрээгээр хамтран ажиллаж байгаа Ган хийцийн бааз дээр 4 байршилд камержуулж, онлайнаар хяналт тавин ажиллах боломжийг бүрдүүлсэн. *(Зураг 2)*

5.4.2.Жолооч нарыг нэгдсэн мэдээллээр хангах систем нэвтрүүлэх ажил төлөвлөлтийн шатанд явж байгаа бөгөөд оны 4 дүгээр улиралд зохион байгуулагдана. Хэрэгжилт 50%

Хүрсэн үр дүн:Аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Бусад:Олон нийтийн арга хэмжээний хүрээнд

1.Үйлдвэрийн газрын аварга шалгаруулах 5 төрөлт спорт арга хэмжээнд ганцаарчилсан төрөлд алтан медаль-1, мөнгөн медаль-2, хүрэл медаль-2, багийн төрөлд алтан медаль-2, мөнгөн медаль-1 тус тус хүртэж, амжилттай оролцсон.

2.Нийтийн тээврийн салбарын аварга шалгаруулах 7 төрөлт спорт арга хэмжээнд хэлтсийн хяналтын оператор Б.Оюунцэцэг теннис төрөлд алтан медаль, гар бөмбөг төрөлд хүрэл медаль, мөн хяналтын ажилтан М.Доржханд гар бөмбөгийн төрөлд хүрэл медаль хүртэж тус тус амжилттай оролцсон.*(Зураг 3)*

3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын аварга шалгаруулах 4 төрөлт спорт арга хэмжээнд хяналтын оператор Д.Баянмөнх, Б.Оюунцэцэг нар гар бөмбөгийн төрөлд тус тус мөнгөн медаль хүртсэн.

4.Нийслэлийн засаг даргын тамгын газрын төлөвлөгөөт ажлын хүрээнд зохион байгуулагдсан 2 удаагийн их цэвэрлэгээнд оролцож, хотын төвийн тодорхой байршлуудад цэвэрлэгээ хийсэн.

Хэсгийн дундаж үнэлгээ:91,5%

Хэрэгжүүлсэн ажлын Үнэлгээ :96,7%

Дүгнэлт:Тайлант хугацаанд нийт 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын хувьд 100% гүйцэтгэлтэй-27 арга хэмжээ, 80% гүйцэтгэлтэй-1, 50% гүйцэтгэлтэй -1 арга хэмжээ. Хэлтсийн ажлын ерөнхий дундаж үнэлгээ 96,1%-ийн биелэлттэй буюу төлөвлөгөөт ажил бүрэн хэрэгжиж байна.

Зорилт-1."Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн"-93,3%
Зорилт-2."Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн"-100%
Зорилт-3."Байгууллагын үйл ажиллагааны үр дүн"-98,7%
Зорилт-4."Байгууллагын ил тод байдал, түүний хэрэгжилт үр дүн"-100%
Зорилт-5.Бусад ажлын хүрээнд:- 91,5%

Ерөнхий дундаж үнэлгээ 96,7%

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:

"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА О.ГАНБААТАР

(албан тушаал) *(гарын үсэг)* *Огноо*_____

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОТГОНБААТАР

(албан тушаал) *(гарын үсэг)* *Огноо* 2023.12.19

*ТАЙЛАГНАСАН:*ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН

ХЯНАЛТЫН АЖИЛТАН М.ДОРЖХАНД

(албан тушаал) *(гарын үсэг)* *Огноо* 2023.12.19